

БАТЛАВ.
“УБЦТС” ТӨХК-ИЙН ҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ




Д.БАЯРСАЙХАН

**“ХУВААРИЛАХ БАЙГУУЛАМЖ” АЖЛЫН БАГЦ-1, 6-10 КВ-ЫН ХУВААРИЛАХ САМБАР
НИЙЛҮҮЛЭХ 2018/332 ДУГААР ГЭРЭЭГ ДҮГНЭСЭН ПРОТОКОЛ**

2020 оны 06 сарын 09

БАТЛАВ.
“ЖЕНЕРАЛ ЭНЕРГО СТРОЙ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Д.БУЯНТОГТОХ

Улаанбаатар хот

Нэг талаас “УБЦТС” ТӨХК-ийн Нийтлэг үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал О.Отгонбаяр, нөгөө талаас “Женерал энерго строй” ХХК-ийг төлөөлж Захирал Д.Буянтогтох нар “УБЦТС” ТӨХК, “Женерал энерго строй” ХХК-ийн хооронд 2018 оны 09 дүгээр сарын 05-нд байгуулсан 2018/332 дугаартай гэрээний хэрэгжилт хангагдсан тул бараа хүлээлцсэн актыг үндэслэн дараах байдлаар энэхүү протоколыг үйлдэв. Үүнд:

1. “Женерал энерго строй” ХХК нь “Хуваарилах байгууламж” ажлын багц-1, 6-10 кВ-ын хуваарилах самбар нийлүүлэхээр нийт 318,743,750 (гурван зуун арван найман сая долоон зуун дөчин гурван мянга долоон зуун тавь) төгрөгөөр 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор нийлүүлэхээр гэрээ байгуулсан байна.

2. “Женерал энерго строй” ХХК нь “Хуваарилах байгууламж” ажлын багц-1, 6-10 кВ-ын хуваарилах самбар нийлүүлэх ажлыг нийт 318,743,750 (гурван зуун арван найман сая долоон зуун дөчин гурван мянга долоон зуун тавь) төгрөгөөр 2020 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр “УБЦТС” ТӨХК-ийн Хангамж үйлчилгээний албаны дарга Ш.Оюунчимэг, мэргэжилтэн Б.Ууганбаяр, ӨХТТ-ийн дарга Ж.Баатархүү, ТБЗХ-ийн инженер Ч.Батбаяр, Санхүү бүртгэлийн хэлтсийн нярав Б.Минжин нарт хүлээлгэн өгч бараа хүлээлцсэн актыг баталгаажуулсан байна.

3. Захиалагч нь гэрээт ажлын урьдчилгаа төлбөр олгоогүй болно.

Гэрээний биелэлтийг дүгнээд шийдвэрлэсэн нь:

➤ “Женерал энерго строй” ХХК нь гэрээний үүргээ биелүүлсэн байна гэж үзэн, Гэрээний дагуу чанарын баталгааны 5 хувь болох 15,937,187.5 (арван таван сая есөн зуун гучин долоон мянга нэг зуун наян долоон төгрөг тавин мөнгө) төгрөг, Гэрээний тусгай нөхцөл 5.1-д заасны дагуу 14,514,300 (арван дөрвөн сая таван зуун арван дөрвөн мянга гурван зуу) төгрөгийг тус тус авч үлдэн 288,292,262.5 (хоёр зуун наян найман сая хоёр зуун ерэн хоёр мянга хоёр зуун жаран хоёр төгрөг тавин мөнгө) төгрөг төлөх нь зүйтэй гэж үзэв.

➤ Чанарын баталгааны 12 сарын хугацаа дуусахад холбогдох төлбөрийг Хангамж үйлчилгээний албаны тодорхойлолтын дагуу буцаан олгоно.

➤ Протоколд бараа хүлээлцсэн актыг хавсаргав.

ГЭРЭЭ ДҮГНЭСЭН:

УБЦТС ТӨХК-ИЙН

НИЙТЛЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН
ДЭД ЗАХИРАЛ

О.ОТГОНБАЯР

САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

О.АРИУНБОЛД

ХАНГАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ
ДАРГА

Ш.ОЮУНЧИМЭГ

ЗХНХ-ИЙН ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН

Б.УРАНГОО

ХАНГАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ
МЭРГЭЖИЛТЭН

Б.УУГАНБАЯР

**“ЖЕНЕРАЛ ЭНЕРГО СТРОЙ” ХХК -ИЙН
ЗАХИРАЛ**

Д.БУЯНТОГТОХ